

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/15/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүү аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас:51-261628 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261885 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Хараат Бус Аудиторын Дүгнэлт	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.5.1 Төсвийн төлөвлөлт	18
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	19
3.5.3 Нэмэлт төсөв.....	20
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	21
4. АУДИТЫН ТАЙЛАН	22
4.1 Ерөнхий зүйл.....	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	23
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.5.1 Завсрын аудитын талаар.....	24
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.1 Албан шаардлага:.....	26
5.2 Зөвлөмж	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНҮТ	Ахмад настны үндэсний төв
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
БНСУ дахь	Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
ХНХҮТ	үйлчилгээний төв
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ОБҮДХЭТ	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ З.БАУЫРЖАН ТАНАА

2026.03.25 № 797
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,467.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Харьяа зарим байгууллагын хөрөнгийн тооллогын комисс нь тооллого хийсэн тайланд үндсэн хөрөнгийн мөнгөн дүнг санхүүгийн тайланд тусгагдсан дүнгээс нийт 4,130.3 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан, 144.6 сая төгрөгийн бараа материалыг тооллогод хамруулаагүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй зохион байгуулсан;
2. Тайлант онд зарим байгууллагууд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулаагүй нэмэлт санхүүжилтийн дансанд 117.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулсан;
3. Харьяа байгууллагууд нь бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс худалдан авах зардлаас 1.2 сая төгрөгийн, урсгал засварын зардлаас 4.1 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 79.7 сая

- төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 7.7 сая төгрөгийн, нийт 92.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн;
4. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 111.5 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн, 95.3 сая төгрөгөөр батлагдсан төсвийг зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, 71 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, 72 дугаар зүйлийн 72.4 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Хөрөнгө хуваарилах тухай” А/131, А/146 дугаар тушаалаар нийт 1,125.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Азийн хөгжлийн банкны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-ийн хүрээнд нийт 1,208.2 сая төгрөгийн компьютер, сүлжээний болон бусад төрлийн төхөөрөмжийг харьяа байгууллагуудад хуваарилсныг данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 196 дугаар тогтоолоор Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын чиг үүргийг төрийн захиргааны болон харьяа дүүргийн холбогдох байгууллагад шилжүүлж, тус газрын 465.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 434 дүгээр тогтоолоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүлээлгэн өгснийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Бусад асуудал

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Төрийн захиргаа, санхүү удирдлагын газар, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар, Халамж үйлчилгээний хэлтэс, Гадаад харилцаа, сургалт хөтөлбөрийн хэлтэс нь даргагүй, даргын албан үүргийг 1 жилээс дээш хугацаагаар хавсран гүйцэтгүүлж байгаа нь хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр төрөл	Тодруулга	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		3,750,982.9	3,886,492.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	422,785.3	27,452.0
33	АВЛАГА	5а,5б,6а,6б	637,754.1	1,652,062.3
34	УРЬДЧИЛГАА	7а,7б	19,464.1	15,476.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а,8б,8в	2,670,979.3	2,191,501.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		58,143,763.2	59,502,527.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		58,143,763.2	59,502,527.7
39200	Биет хөрөнгө		50,450,946.2	52,164,556.5
39300	Биет бус хөрөнгө	13	7,692,817.1	7,337,971.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		61,894,746.1	63,389,020.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		37,313.2	330,253.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		37,313.2	330,253.9
41300	Өглөг		37,313.2	330,253.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		61,857,432.8	63,058,766.4
51	Засгийн газрын хувь оролцоо		61,857,432.8	63,058,766.4
51100	Засгийн газрын оруулсан капитал		16,278,018.0	16,278,018.0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		16,278,018.0	16,278,018.0
51200	Хуримтлагдсан үр дүн		38,815,199.0	40,160,639.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		6,764,215.9	6,620,109.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		61,894,746.1	63,389,020.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр төрөл	Тодруулга	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		92,538,129.7	93,604,665.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	12,464,091.3	93,604,665.7
120	Нийтлэг татварын бус орлого		12,464,091.3	13,769,019.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		80,074,038.4	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	88,149,730.4	91,264,281.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		88,149,730.4	91,264,281.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		74,422,634.2	81,287,168.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		52,549,430.2	59,251,549.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		6,410,001.4	7,077,987.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,190,816.4	3,448,448.2
2104	Хангамж, бараа материалын зардал		1,476,218.8	1,168,245.8
2105	Нормативт зардал		2,105,010.7	2,451,357.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		620,190.1	411,078.1
2107	Томилолт, зочны зардал		296,065.1	311,313.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,766,504.2	1,961,200.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		5,008,397.3	5,205,989.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,727,096.2	9,977,112.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,388,399.4	2,340,384.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		1,394.2	32,389.3

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,059,684.9	1,141,977.0
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(1,058,290.7)	(1,109,587.8)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		3,330,108.6	1,230,796.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр төрөл	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	85,876,630.4	86,469,761.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,783,717.8	86,469,761.9
120	Нийтлэг татварын бус орлого	5,783,717.8	6,632,715.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,623,922.7	6,632,505.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,609,964.0	4,546,303.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,989,637.6	2,086,202.0
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	24,321.0	-
120009	Бусад орлого	159,795.2	210.0
122	Тусламжийн орлого	-	79,837,046.9
1221	Хандив тусламж /дотоод/	-	79,837,046.9
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	74,564,274.2
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	74,564,274.2
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,272,772.7
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	187,873.2
122132	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	26,440.5
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,686,046.0
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	254,750.1
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	117,662.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	80,092,912.5	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	73,213,684.7	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	73,213,684.7	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,879,227.9	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	252,161.2	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,759,617.4	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,408,615.3	-

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	458,833.9	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,742,812.2	86,694,894.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,742,812.2	86,694,894.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,947,437.0	75,829,175.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,547,808.0	59,090,964.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,374,519.1	7,091,642.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,165,930.8	3,411,945.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,265,251.0	830,537.6
2105	Нормативт зардал	2,721,555.0	2,179,189.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	610,398.1	367,945.9
2107	Томилолт, зочны зардал	296,425.1	302,616.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,191,430.2	2,230,164.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	774,119.7	324,168.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,795,375.2	10,865,719.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,133,818.1	(225,132.6)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	831,221.0	147,777.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	831,221.0	147,777.3
2200	Дотоод эх үүсвэрээр	831,221.0	147,777.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(831,221.0)	(147,777.3)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	31,738.7	22,423.4
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	31,738.7	22,423.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(31,738.7)	(22,423.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	270,858.4	(395,333.3)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	151,926.9	422,785.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	422,785.3	27,452.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр өмч/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,031,474.2		58,031,474.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	266,777.7		266,777.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,298,251.9		58,298,251.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(105,885.7)		(105,885.7)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	334,958.0		334,958.0
6	Тайлант үеийн үр дүн	3,330,108.6		3,330,108.6
7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,857,432.8		61,857,432.8
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	151,301.4		151,301.4
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	62,008,734.3		62,008,734.3

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(180,764.6)		(180,764.6)
11	Тайлант үеийн үр дүн	1,230,796.7		1,230,796.7
12	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,058,766.4		63,058,766.4

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	78,531,346,800.00	74,068,372,783.91	4,462,974,016.09	94.3
12	Татварын бус орлого	78,531,346,800.00	74,068,372,783.91	4,462,974,016.09	94.3
120	Нийтлэг татварын бус орлого	2,021,292,300.00	2,760,050,051.47	(738,757,751.47)	136.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	351,656,200.00	711,225,636.54	(359,569,436.54)	02.3
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	1,669,636,100.00	2,048,824,414.93	(379,188,314.93)	122.7
122	Тусламжийн орлого	76,510,054,500.00	71,308,322,732.44	5,201,731,767.56	93.2
122005	Төсвөөс санхүүжих	76,510,054,500.00	71,308,322,732.44	5,201,731,767.56	93.2
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,531,346,800.00	73,043,741,859.61	5,487,604,940.39	93.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,531,346,800.00	73,043,741,859.61	5,487,604,940.39	93.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,955,706,900.00	71,754,554,566.85	5,201,152,333.15	93.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,092,009,000.00	56,569,578,534.56	2,522,430,465.44	95.7
210101	Үндсэн цалин	28,873,345,800.00	28,046,173,203.47	827,172,596.53	97.1
210102	Нэмэгдэл	17,987,149,100.00	16,670,129,580.93	1,317,019,519.07	92.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,706,961,800.00	8,393,473,984.98	(686,512,184.98)	108.9
210104	Урамшуулал	4,524,552,300.00	3,459,801,765.18	1,064,750,534.82	76.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,093,130,200.00	6,792,096,817.71	301,033,382.29	95.8
210201	Тэтгэврийн даатгал	4,814,832,800.00	4,642,182,634.24	172,650,165.76	96.4
210202	Тэтгэмжийн даатгал	564,208,200.00	556,213,833.23	7,994,366.77	98.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	292,164,200.00	270,539,809.76	21,624,390.24	92.6
210204	Ажилгүйдлийн даатгал	291,644,700.00	267,042,740.02	24,601,959.98	91.6
210205	Эрүүл мэндийн даатгал	1,130,280,300.00	1,056,117,800.46	74,162,499.54	93.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,932,135,300.00	3,364,017,781.39	568,117,518.61	85.6
210301	Гэрэл, цахилгаан	793,669,000.00	606,793,031.37	186,875,968.63	76.5
210302	Түлш, халаалт	1,980,782,900.00	1,679,623,844.77	301,159,055.23	84.8
210303	Цэвэр, бохир ус	244,124,300.00	189,487,749.25	54,636,550.75	77.6
210304	Байрны түрээс	913,559,100.00	888,113,156.00	25,445,944.00	97.2
2104	Хангамж, бараа материалын зардал	681,818,400.00	559,081,412.20	122,736,987.80	82.0
210401	Бичиг хэрэг	135,484,000.00	122,858,039.50	12,625,960.50	90.7
210402	Тээвэр, шатахуун	134,891,800.00	114,339,658.44	20,552,141.56	84.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	125,609,600.00	91,450,897.01	34,158,702.99	72.8
210404	Ном, хэвлэл	233,600.00	-	233,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,452,100.00	23,213,700.00	21,238,400.00	52.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	241,147,300.00	207,219,117.25	33,928,182.75	85.9
2105	Нормативт зардал	2,730,868,900.00	2,087,941,186.51	642,927,713.49	76.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	154,778,700.00	107,323,851.60	47,454,848.40	69.3
210502	Хоол, хүнс	2,222,174,700.00	1,665,506,464.91	556,668,235.09	74.9

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	353,915,500.00	315,110,870.00	38,804,630.00	89.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,760,800.00	293,540,372.00	87,220,428.00	77.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,192,800.00	43,663,000.00	4,529,800.00	90.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	105,369,100.00	33,594,400.00	71,774,700.00	31.9
210604	Урсгал засвар	227,198,900.00	216,282,972.00	10,915,928.00	95.2
2107	Томилолт, зочны зардал	417,129,100.00	269,965,025.34	147,164,074.66	64.7
210702	Дотоод албан томиллолт	411,593,400.00	264,540,890.34	147,052,509.66	64.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,535,700.00	5,424,135.00	111,565.00	98.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,197,307,600.00	1,787,523,178.14	409,784,421.86	81.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,855,098,300.00	1,583,000,093.39	272,098,206.61	85.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	70,975,300.00	12,665,800.00	58,309,500.00	17.8
210803	Даатгалын үйлчилгээ	106,306,400.00	96,451,593.10	9,854,806.90	90.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	16,141,800.00	12,741,795.70	3,400,004.30	78.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,272,900.00	1,579,100.00	1,693,800.00	48.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,034,800.00	56,321,195.10	43,713,604.90	56.3
210807	Газрын төлбөр	33,691,900.00	19,853,725.00	13,838,175.00	58.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,982,700.00	4,804,875.85	3,177,824.15	60.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,803,500.00	105,000.00	3,698,500.00	2.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	430,547,600.00	30,810,259.00	399,737,341.00	7.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,826,100.00	8,825,998.00	102.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	421,721,500.00	21,984,261.00	399,737,239.00	5.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,575,639,900.00	1,289,187,292.76	286,452,607.24	81.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,575,639,900.00	1,289,187,292.76	286,452,607.24	81.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,182,000.00	-	29,182,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	911,902,500.00	802,717,988.20	109,184,511.80	88.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	506,450,100.00	359,806,041.56	146,644,058.44	71.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,105,300.00	126,663,263.00	1,442,037.00	98.9
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	1,024,630,924.30	(1,024,630,924.30)	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(1,024,630,924.30)	1,024,630,924.30	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(1,024,630,924.30)	1,024,630,924.30	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,093,398.98	(12,093,398.98)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,153,374.26	(12,153,374.26)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	32	31	1	96.9
610001	Төсвийн байгууллага	32	31	1	96.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,663	1,611	52	96.9
620001	Удирдах ажилтан	34	33	1	97.1
620002	Гүйцэтгэх ажилтан	1,263	1,231	32	97.5
620003	Үйлчлэх ажилтан	366	347	19	94.8

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,272,772,709.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,272,772,709.45
122	Тусламжийн орлого	5,272,772,709.45
1221	Хандив тусламж /дотоод/	5,272,772,709.45
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,272,772,709.45
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	187,873,180.00
350012	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	26,440,500.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,686,046,036.45
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	254,750,100.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	117,662,893.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,226,686,196.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,226,686,196.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,086,277,042.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,521,386,162.72
210101	Үндсэн цалин	415,535,461.35
210102	Нэмэгдэл	1,804,167,108.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,436,996.95
210104	Урамшуулал	251,246,595.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	299,545,688.49
210201	Тэтгэврийн даатгал	221,120,275.12
210202	Тэтгэмжийн даатгал	22,914,655.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,008,248.91
210204	Ажилгүйдлийн даатгал	8,926,569.33
210205	Эрүүл мэндийн даатгал	35,575,939.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,928,055.20
210301	Гэрэл, цахилгаан	6,512,721.69
210302	Түлш, халаалт	38,516,831.31
210303	Цэвэр, бохир ус	2,898,502.20
2104	Хангамж, бараа материалын зардал	271,273,066.64
210401	Бичиг хэрэг	25,164,424.00
210402	Тээвэр, шатахуун	172,947,126.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,760,134.18
210404	Ном, хэвлэл	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,041,382.46
2105	Нормативт зардал	94,063,773.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,583,074.00
210502	Хоол, хүнс	84,480,699.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,065,944.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	56,202,400.00
210602	Тавилга	12,800,000.00
210604	Урсгал засвар	44,063,544.00

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	27,276,000.00
210702	Дотоод албан томилолт	27,276,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	521,313,182.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	521,204,182.82
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	109,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	190,425,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,674,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,750,230.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,140,409,154.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,140,409,154.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	151,394,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,765,054.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	961,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,250,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	46,026,512.58
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(46,086,512.58)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(46,086,512.58)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд оновчтой хүргэх, чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулах замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн эрсдэлд суурилсан хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан тэргүүлэх чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшнийг бууруулах;
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх;
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дээшлүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх;
- Байгууллагын гадаад, дотоод харилцааг хөгжүүлж салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх талаар хамтран ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ, мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах;
- Салбарын хууль тогтоомж, норм, нормативыг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн эрсдэлд суурилсан хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тайлант оны онцлог үйл явдлуудаас дурдвал:

- Засгийн газрын 2024 оны “Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2025 оны “тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 196 дугаар тогтоолоор Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрыг татан буулгасан;
- Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор ХХҮЕГ-ын орон тооны дээд хязгаарыг 83 байхаар баталсан;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 29,901 иргэн хамрагдаж, 43,807.7 сая төгрөг зарцуулсан;
- ГБХНХС, Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ батлах тухай” А/51/37 дугаар хамтарсан тушаалаар хувилбарт үйлчилгээ үзүүлэх тарифыг шинэчлэн баталсан;
- Японы Жайка Олон Улсын байгууллагаас “Монгол улсын зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд ажил турших хөтөлбөрийг Улаанбаатар хотын БЗД, СБД, Дундговь аймагт загвар төсөл хэлбэрээр хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

ХХҮЕГ-ын стратегийн мөн чанар нь “Хүн амын хөгжлийг хангах таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажиллах хүчний нөөцийг зохистой ашиглах, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх бодлого, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллөөс

хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, үйлчлүүлэгч төвтэй, мэргэшсэн чадварлаг, ёс зүйг дээдэлсэн манлайлагч байгууллага болно.” гэж тодорхойлсны дагуу дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Тухайлбал:

- Салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, Монгол Улсын иргэдийг сургах, дадлагажуулах чиглэлээр гадаадаас өндөр ур чадвартай ажиллах хүч, мэргэжилтэн авах, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадад ажиллах хүч гаргах үйл ажиллагааг хууль тогтоомж, төрийн бодлого, шийдвэрийн дагуу зохион байгуулах;
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ядуурлын түвшнийг бууруулах;
- Бодлогын хэрэгжилтийн явц, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг тодорхойлж мэргэжил арга зүйгээр хангах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг ил тод, нээлттэй болгож, хяналтыг сайжруулах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бодлогын загварчлал боловсруулах, салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, хөгжүүлэх.

ХХҮЕГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, тогтоомжийг мөрдлөг болгож байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйл “гадаад ажилтны ажлын байрны төлбөр”;
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл “Баялгийн сангийн эх үүсвэр”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар нь 2025 онд 6 аймаг, 3 дүүрэг, ХХҮЕГ-ын үйл ажиллагаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэн, 5.2 сая төгрөгийн 2 зөрчилд

санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн акт, зөрчил арилгах 9 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 50 хугацаатай зөвлөмжийг өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХХҮЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ХХҮЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 63,389.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,494.3 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	422,785.3	27,452.0	(395,333.3)
Авлага	637,754.1	1,652,062.3	1,014,308.2
Урьдчилгаа	19,464.1	15,476.8	(3,987.3)
Бараа материал	2,670,979.3	2,191,501.5	(479,477.8)
Үндсэн хөрөнгө	58,143,763.3	59,502,527.7	1,358,764.4
Нийт хөрөнгө	61,894,746.1	63,389,020.3	1,494,274.2
Өглөг	37,313.2	330,253.9	292,940.7
Засгийн газрын хувь оролцоо	61,857,432.9	63,058,766.4	1,201,333.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	61,894,746.1	63,389,020.3	1,494,274.2

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо дансууд байна. Тухайлбал:

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 27.5 сая төгрөг болж, өмнөх оноос 395.3 сая төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	405,677.1	0	(405,677.1)
Арилжааны банк дахь харилцах	5,014.8	15,308.6	10,293.8

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Замд яваа мөнгөн хөрөнгө	12,093.4	12,143.4	50.0
Дүн	422,785.3	27,452.0	(395,333.3)

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд Төрийн сан банк дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд харьяа байгууллагуудын Ахмадын сангийн үлдэгдэл 405.7 сая төгрөг байршиж байсныг тайлант онд улсын төсөв төвлөрүүлсэн нь мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 395.3 сая төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна.

Арилжааны банк дахь харилцахын мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ХХҮЕГ-ын 15.3 сая төгрөгийн гадаадад ажилтан илгээх бүртгэлийн үлдэгдэл, БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн замд яваа хадгаламжийн үлдэгдэл 12.1 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад мөнгөн хөрөнгө данстай холбоотой нийт 393.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү тооцож олгосон, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу суутгасан зэрэг нийт 186.6 сая төгрөг; /ХХҮЕГ 36.8 сая төгрөг, Булган аймгийн ХХҮГ 13.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ХХҮГ 1.4 сая төгрөг, Дорноговь аймгийн ХХҮГ 3.3 сая төгрөг, Нийслэлийн ХХҮГ 37.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ХХҮГ 19.5 сая төгрөг, Ховд аймгийн ХХҮГ 21.7 сая төгрөг, Хөвсгөл аймаг 1.8 сая төгрөг, Орхон аймгийн ХХҮГ 6.0 сая, Өвөрхангай аймаг 4.0 сая төгрөг, АНУТөв 35.3 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ХХҮГ 0.5 сая төгрөг, Дорнод аймгийн ХХҮГ 0.4 сая төгрөг, Өмнөговь аймгийн ХХҮГ 4.3 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ХХҮГ 0.2 сая төгрөг/
- Батлагдсан төсвийг нийт 95.3 сая төгрөгөөр зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан; /Орхон аймгийн ХХҮГ 4.0 сая, Завхан аймгийн ХХҮГ 6.0 сая, Дорноговь аймгийн ХХҮГ 30.9 сая төгрөг, ХХҮЕГ 18.4 сая төгрөг, БЗД ХХҮГ 36.0 сая төгрөг/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ 111.5 сая төгрөг; /ХХҮЕГ 36.9 сая төгрөг, БНСУ дахь ХНХҮТ 24.3 сая төгрөг, Завхан аймгийн ХХҮГ 2.4 сая төгрөг, Нийслэлийн ХХҮГ 47.9 сая төгрөг/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,652.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,014.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), бууралт(-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	28,319.5	29,734.0	1,414.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	3,414.9	1,839.7	(1,575.2)
Татаас, санхүүжилтийн авлага	36,443.8	978,307.8	941,864.0
Байгууллагаас авах авлага	355,223.4	218,539.6	(136,683.8)
Хувь хүмүүсээс авах авлага	214,352.3	423,641.0	209,288.7
Дүн	637,754.1	1,652,062.1	1,014,308.2

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 980.1 сая төгрөгийн татаас санхүүжилтийн болон төлбөртэй үйлчилгээний авлага, бараа, ажил үйлчилгээтэй холбоотой 218.5 сая төгрөгийн, хувь хүн, ажиллагсадтай холбоотой 453.3 сая төгрөгийн авлагууд байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос өсөхөд харьяа байгууллагуудын татаас санхүүжилтийн авлага 941.8 сая төгрөгөөр, хувь хүмүүсээс авах авлага 209.3 сая төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад авлага данстай холбоотой нийт 117.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Авлагын 13.0 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй; /АНУТ 11.4 сая төгрөг, ХУД 10.6 сая төгрөг, Төв аймгийн ХХҮГ 1.0 сая төгрөг/
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг зөрчин 3 албан хаагчид байрны барьцааны төлбөр 94.3 сая төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 24-ны өдөр зарцуулж, авлага үүсгэсэн. /БНСУ дахь ХНХҮТ/

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 15.5 сая төгрөг болж, өмнөх оноос 3.9 сая төгрөгөөр буурсан байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), бууралт(-)
Урьдчилж гарсан зардал	19,464.1	15,476.8	(3,987.3)
Дүн	19,464.1	15,476.8	(3,987.3)

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд ХХҮЕГ-ын Шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсон албан хаагчийн нийгмийн даатгалын нөхөн тайлан баталгаажуагүйн улмаас нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 15.4 сая төгрөг үлдэгдэлтэй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 2,191.5 сая төгрөг болж, өмнөх оноос 418.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	111,620.3	66,636.8	(44,983.5)
Тусгай зориулалттай материал	20,399.8	5,290.5	(15,109.3)
Эм боох материал	91,220.5	59,866.3	(31,354.2)
Бэлэн бүтээгдэхүүн	1,480.0	1,480.0	-
Хангамжийн материал	2,498,678.9	2,124,864.6	(373,814.3)
Бичиг хэргийн материал	118,431.4	53,306.9	(65,124.5)
Аж ахуйн материал	796,968.8	760,230.0	(36,738.8)
Сэлбэг хэрэгсэл	66,123.0	68,963.5	2,840.5
Түлш, шатах тослох материал	77,858.3	58,372.0	(19,486.3)
Барилгын засварын материал	12,270.9	14,178.9	1,908.0
Хүнсний материал	524,809.7	314,565.4	(210,244.3)
Бусад хангамжийн материал	902,216.5	852,072.9	(50,143.6)
Мал амьтад	59,200.0	3,175.0	(56,025.0)
Дүн	2,670,979.2	2,191,501.4	(418,797.8)

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 96.9 хувийг хангамжийн материал, 3.1 хувийг түүхий эд материал эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,757.5 сая төгрөг үнэ төлбөргүй хүлээн авсан 45.3 сая төгрөг, балансаас балансад шилжүүлсэн 14.3 сая төгрөг, нийт 3,817.1 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд 4,247.3 сая төгрөгийг зарцуулж, балансаас баланст шилжүүлсэн 15.4 сая төгрөг, данс хооронд болон акталсан 95.1 сая төгрөг, нийт 4,357.8 сая төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна.

Бараа материалын үлдэгдэл буурахад бичиг хэргийн материал 65.1 сая төгрөг, аж ахуйн материал 36.7 сая төгрөгөөр, түлш шатах тослох материал 19.5 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 50.1 сая төгрөгөөр, хүнсний материал 210.2 сая төгрөгөөр, түүхий эд материал 44.9 сая төгрөг, мал амьтад 56.0 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад бараа материалын данстай холбоотой нийт 396.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн.Тухайлбал:

- Асруулагчийн хоолны зардлыг батлагдсан нормативаас 122.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 40.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн; /АНҮТ/
- Худалдан авалтын гэрээний дүнгээс илүү худалдан авалт хийсэн, худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь зөрүүтэй зэрэг нийт 43.9 сая төгрөг; /АНҮТ 40.2 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ХХҮГ 3.7 сая төгрөг/
- Бараа материалын 14.9 сая төгрөгийн үлдэгдэлд тооцоо бодож акт үйлдээгүй; /ХУД ХХҮГ 6.4 сая төгрөг, СХД ХХҮГ 8.5 сая төгрөг/

- Хөрөнгийн тооллогын комисс нь 144.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй. /ХХҮЕГ/

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 59,502.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,358.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Биет хөрөнгө	50,450,946.1	52,164,556.5	1,358,764.4
Барилга, байгууламж, орон сууц	42,665,935.5	43,543,673.2	(877,737.7)
Авто-тээврийн хэрэгсэл	266,583.4	278,605.7	12,022.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,063,836.3	6,912,037.5	848,201.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,042,524.6	957,141.0	(85,383.5)
Бусад үндсэн хөрөнгө	410,448.9	472,359.8	54,351.3
Ном	1,617.4	739.3	(878.1)
Биет бус хөрөнгө	7,692,817.0	7,337,971.2	(354,845.8)
Программ хангамж	2,321,618.0	1,936,378.9	(385,239.2)
Бусад биет бус хөрөнгө	5,371,199.0	5,401,592.3	30,393.3
Дүн	58,143,763.2	59,502,527.7	1,358,764.5

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн 73.0 хувийг барилга, байгууламж, 14 хувийг тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл болон бусад үндсэн хөрөнгө, 13 хувийг биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 150.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар 448.3 сая төгрөг, шилжүүлэн авсан 6,741.0 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 199.8 сая төгрөг, нийт 7,539.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 3,984.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 1,804.3 сая төгрөгийн хөрөнгийг байгууллага хооронд шилжүүлж, хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол 111.1 сая төгрөг, нийт 6,239.5 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 610.6 сая төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт: ХХҮЕГ-ын харьяа байгууллагуудад үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 4,467.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Хөрөнгийн тооллогын комисс нь тооллогын хийсэн тайланд үндсэн хөрөнгийн мөнгөн дүнг санхүүгийн тайлангийн дүнгээс 4,130.3 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан, 4.4 сая төгрөгийн хөрөнгийн нь дансанд бүртгэлгүй байгаа нь тооллогыг чанаргүй хийсэн; /ХХҮЕГ 4,130.3 сая төгрөг, НД-ийн ХХҮГ 4.4 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 150.6 сая төгрөгийн хөрөнгийг нотлох баримтгүй акталж устгасан; /БЗД ХХҮГ 148.0 сая төгрөг, Нийслэлийн ХХҮГ 2.6 сая төгрөг/
- Байгууллагын эзэмшилд байгаа 4.0 сая төгрөгийн газрыг үндсэн хөрөнгөнд бүртгээгүй, тавилга эд хогшлын дансанд 10 нэр төрлийн 13.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэсэн зэрэг үндсэн хөрөнгийг ангиллыг буруу бүртгэсэн, нийт 17.5 сая төгрөг /БЗД ХХҮГ 4.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн ХХҮГ 13.5 сая төгрөг/
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 19.7 сая төгрөгийг хөрөнгийг асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлэх арга хэмжээ аваагүй; /БНСУ дахь ХНХҮТ/

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 330.3 сая төгрөг болж, өмнөх оноос 292.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	20,259.7	35,219.0	16,081.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	565.7	66,910.7	66,345.0
Байгууллагад төлөх өглөг	1,056.9	104,535.3	103,478.4
Хувь хүмүүст төлөх өглөг	15,430.8	114,167.8	98,737.0

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Татварын өглөг		2,753.9	2,753.9
НДШ-ийн өглөг		6,666.9	6,666.9
Дүн	37,313.2	330,253.8	292,940.7

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 292.9 сая төгрөгөөр өссөн нь харьяа байгууллагуудад 2025 оны 12 дугаар сарын санхүүжилт дутуу олгогдсоноос тогтмол зардлын өглөг өссөн, мөн орон тооны цомхотголоор ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох тэтгэмжийн өглөг өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ХХҮЕГ-ын харьяа байгууллагуудад өглөгийн данстай холбоотой нийт 61.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.Тухайлбал:

- Өмнөх оны 47.9 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, тайлант онд 2.2 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан; /Өмнөговь аймгийн ХХҮГ/
- Төв аймгийн ХХҮГ нь 11.1 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй;

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 61.8 сая төгрөг болж, өмнөх оноос 3.8 сая төгрөгөөр өссөн.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	16,278,017.9	16,278,017.9	-
Хуримтлагдсан үр дүн	38,815,198.9	40,160,639.0	1,345,440.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,764,215.9	6,620,109.4	(144,106.5)
ДҮН	61,857,432.8	63,058,766.3	1,201,333.5

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс өсөхөд 1,201.3 сая төгрөгийн тайлант үеийн үр дүн голлон нөлөөлсөн.

Харьяа байгууллагуудаас программ хангамжийн талаарх судалгаа авахад 4,784.5 сая төгрөгийн үнэ бүхий 60 программыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Харьяа байгууллагууд нь санхүүгийн “Аксplorер” программыг ашигладаг бөгөөд тайлант онд программын лицензийн төлбөрт 17.2 сая төгрөгийг зарцуулсан байна. ХХҮЕГ нь тайлант онд ашиглагдахгүй болсон 13 нэр төрлийн 1,592.2 сая төгрөгийн программ хангамжийг данснаас хасаж, акталсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

ТТЗ-ийн 2025 оны төсвийн төсөлд урсгал үйл ажиллагааны зардлыг 78,355.9 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 287.7 сая төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлогыг 2,356.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, зардлыг санхүүжүүлэх эс үүсвэрийг нийт 81,000.1 сая төгрөгөөр төлөвлөн, дээд шатны захирагчид 2024 оны 01/1025 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

ТТЗ-ийн төслийн саналаас зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,134.2 сая төгрөгөөр бууруулж, төсвийн урсгал үйл ажиллагааны зардлыг 77,573.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогыг 235.1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 2,292.9 сая төгрөг, нийт 79,865.9 сая төгрөгөөр баталжээ.

Тайлант оны батлагдсан төсвийг урсгал зардлыг 1,063.0 сая төгрөгөөр бууруулж, 76,510.0 сая төгрөгөөр, төсвийн байгууллагын хүрээнд бий болох орлогыг 271.6 сая төгрөгөөр бууруулж 2,021.3 төгрөгөөр, нийт зардлыг санхүүжүүлэх эс үүсвэрийг 78,531.3 сая төгрөгөөр

тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд 76,510.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал үйл ажиллагаанд 71,308.2 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2,760.0 сая төгрөгийг олж, үйл ажиллагаанд 73,043.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,024.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор 351.7 сая төгрөгийн бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 711.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 359.5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Хүснэгт 9. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Орлогын төлөвлөгөө	Орлогын гүйцэтгэл	Зөрүү
Сэлэнгэ аймгийн ХХҮГ	4,800.0	5,425.0	625.0
Ахмад настны үндэсний төв	195,081.6	515,727.9	320,646.3
ХХҮЕГ	151,774.6	190,072.6	38,298.0
Дүн	351,656.2	711,225.6	359,569.3

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 74,068.4 сая төгрөг буюу 94.3 хувьтай байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
72206	Хөдөлмөр халамжийн үйлчилгээ	78,531,346.8	74,068,372.8	4,462,974.0	94.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	76,955,706.9	72,779,185.5	4,176,521.4	94.5
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,575,639.9	1,289,187.3	286,452.6	81.8

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг нэгтгэн, тайланд тусгалаа. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжуулалтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авсан.

Харьяа байгууллагуудын орон тоог ХХҮЕГ-ын даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар 1867 орон тоотой байхаар баталсныг ТТЗ-ийн 2025 оны А/327 дугаар тушаалаар 1663 болгон 10 хувиар бууруулсан байна. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын тайлант оны төсөвт 59,092.0 сая төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас 56,569.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд ХХҮЕГ-ын /аппарат/ орон тоо 72 байсныг Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга

хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор 83 болгон нэмэгдүүлж, бүтцэд Нийслэлийн ХХҮГ-ын 11 орон тоог нэмж баталсан байна. Тайлант хугацаанд 69 орон тоотой үйл ажиллагаа явуулж, 2,616.9 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулжээ.

2. Тайлант онд хоол, унааны зардалд нийт 7,706.9 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 8,393.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 686.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын өдрийн хоол унааны хөнгөлөлтийн зардал харилцан адилгүй 15.0-34.0 мянган төгрөг байна. Тухайлбал:
 - Баянхонгор аймгийн ХХҮГ нь аймгийн мэргэжилтнүүдийн өдрийн хоолны зардлыг 34.0 мянган төгрөг, сумын мэргэжилтнүүдийн өдрийн хоолны зардлыг 20.0 мянган төгрөг;
 - Өмнөговь аймгийн ХХҮГ нь аймгийн мэргэжилтнүүдийн өдрийн хоолны зардлыг 34.0 мянган төгрөг, сумын мэргэжилтнүүдийн өдрийн хоолны зардлыг 20.0 мянган төгрөг, төрийн үйлчилгээний ажилтнуудын өдрийн хоолны зардлыг 17.0 мянган төгрөг;
 - Булган аймгийн ХХҮГ нь 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар албан хаагчдын өдрийн хоолны зардлыг 15.0 мянган төгрөгөөр тогтоосныг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Б/128 дугаар тушаалаар 30.0 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн байна.
3. ТТЗ-ийн хэмжээгээр тайлант оны төсөвт гадаад томилолтын зардал батлагдаагүй бөгөөд ХХҮЕГ нь дотоод томилолтын зардлаас 18.1 сая төгрөгийг гадаад томилолтын зардалд зарцуулсан. Дээрх зөрчилд зөрчил таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлсэн.
4. Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 421.7 сая төгрөг батлагдсанаас тайлант хугацаанд 21.9 сая төгрөгийг зарцуулсан. Тайлант онд ХХҮЕГ нь 1 удаагийн сургалт зохион байгуулж, 0.1 сая төгрөгийг зарцуулсан байна.
5. ХХҮЕГ-ын харьяа Орхон аймгийн ХХҮГ нь тайлант онд контент бүтээхэд ахмадын сангийн зардлаас 0.4 сая төгрөгийг зарцуулсан.
6. ХХҮЕГ нь тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой 36.8 сая төгрөгийг цалин, нэмэгдэл хөлс олгох зардлаас зарцуулсан албан шаардлага хүргүүлжээ.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр Засаг даргын нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан 4,686.0 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 187.9 сая төгрөг, төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 26.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 254.8 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 117.6 сая төгрөг, нийт 5,272.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлснээс 5,226.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 46.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ХХҮЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар 2025 онд худалдан авах бараа ажил, үйлчилгээний жагсаалтыг баталж, 402.4 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн.

Тайлант онд дараах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

1. ХХҮЕГ-ын үндсэн үйл ажиллагаанд шаардагдах бараа худалдан авахад 151.4 сая төгрөг;
2. ХХҮЕГ, аймаг дүүргийн нэгдсэн VPN интернэт сүлжээ болон сумдыг 4G сүлжээнд холбох, интернэтээр хангах үйлчилгээний зардалд 86.9 сая төгрөг;
3. ХХҮЕГ-ын харуул хамгаалалтын үйлчилгээний байгууллагыг сонгон шалгаруулах үйлчилгээний зардалд 72.0 сая төгрөг;
4. ХХҮЕГ-ын байр ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээний байгууллагыг сонгон шалгаруулах үйлчилгээний зардалд 92.0 сая төгрөг.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ХХҮЕГ-ын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ХХҮЕГ-ын ТТЗ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

ХХҮЕГ-ын ТТЗ-ийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн зарцуулалт, зардлын эдийн засгийн ангилал, өглөг, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөхжаргал нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

ХХҮЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01/382 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 88,149.7 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 881.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аудитын илрүүлэлт: Орхон аймгийн ХХҮГ нь Ахмадын сангаас ахмадуудын контент бүтээхэд 0.4 сая төгрөгийг зарцуулсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 1,036.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 374.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлагыг хүргүүлж, 68.2 сая төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага, 593.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 14 зөвлөмж өгсөн. Үүнээс ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг 20-ос доошгүй хувиар бууруулах 1 албан шаардлага, зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт 1: ТТЗ-ийн харьяа 9 байгууллага нь Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг хугацааг хоцруулсан, мэдээлээгүй зэрэг нийт 482.4 сая төгрөгийн зөрчил төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн.

- Цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүнтэй 423.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй. / Өвөрхангай аймгийн ХХҮГ 210.6 сая төгрөг, Баянхонгор аймгийн ХХҮГ 97.0 сая, БНСУ дахь ХНХҮТ 78.0 сая төгрөг, ХХҮЕГ 37.5 сая төгрөг /
- Шилэн дансны цахим хуудсанд 59.1 сая төгрөгийн тушаал шийдвэр, нотлох баримтыг хавсаргаагүй. / Хөвсгөл аймгийн ХХҮГ 58.2 сая төгрөг, Дундговь аймгийн ХХҮГ 0.9 сая төгрөг /

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;", 8 дугаар зүйлийн 8.4-т "Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.", Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт 2: ТТЗ нь Шилэн дансны цахим системд нэвтрэх эрхгүй, бие даасан цэсгүйгээс харьяа байгууллагын батлагдсан төсвийн хуваарь, өөрчлөлт, төсвийн төсөл, ТТЗ-ийн аудитын тайлан болон санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан зэрэг хуулийн дагуу мэдээлбэл зохих мэдээллүүд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;", 5 дугаар зүйлийн 5.1 "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна: 5.1.1-д "5.1.1.шилэн дансны бие даасан цэстэй байх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хандан шилэн дансны цахим системд ТТЗ-ийн бие даасан цэс үүсгүүлж, байршуулбал зохих мэдээллүүдийг мэдээлж хэвших зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчил илэрлээ.Үүнд:

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад төрд учирсан хохиролтой холбоотой өглөг, авлага жил бүр нэмэгдэж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйл "Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь түр чөлөөлөх, чөлөөлөх", 47 дугаар зүйл "төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь халах"-ийн холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: төрд учирсан хохирлын хэмжээ жил бүр тогтмол нэмэгдэж байгааг анхаарч, цаашид төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас чөлөөлөхдөө Төрийн албаны тухай хуулийг мөрдөж, харьяа байгууллагын удирдлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

1. ХХҮЕГ-ын харьяа БНСУ дахь ХНХҮТ-ийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нийт 294.4 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:
 - БНСУ дахь ХНХҮТ-ийн 2025 оны батлагдсан төсөвт тусгагдаагүй шинээр томилогдсон 2 албан хаагчийн 4-9 дүгээр сарын цалин хөлсөнд нийт 56.9 сая төгрөгийг зарцуулсныг дээд шатны байгууллагад хүсэлт гарган, зардал залруулах бичилт хийлгэсэн;
 - БНСУ дахь ХНХҮТ-ийн албан хаагчдын түрээсийн байрны барьцаа болон ажлын байрны түрээсийн барьцаа төлбөрт нийт 237.5 сая төгрөгийн авлагыг албан хаагчид, ажлын байр түрээслэгчтэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.
2. ХХҮЕГ-ын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нийт 4,161.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн, 4,088.8 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 73.7 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгаагүй тул жилийн эцсийн аудитын үр дүнд оруулж тооцлоо. Үүнд:
 - Анхан шатны нотлох баримтын бүрдэл дутуу, ажлын гүйцэтгэлийн тайлангүй 3 төрлийн ажил, үйлчилгээний нийт 36.9 сая төгрөгийн гүйлгээг бүртгэж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн;
 - ГБХНХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хуулийн дагуу шийдвэр гараагүй байхад Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 197ШШ2025/16317 тоот шүүхийн шийдвэр, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 128ШШ20250370 тоот шүүхийн шийдвэрээр эргэн ажилдаа орсон 2 албан хаагчид цалингийн нэмэгдэл зардлаас 36.8 сая төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн хэмжээг бууруулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, ТТЗ-ийн харьяа байгууллагуудын татаас санхүүжилтийн авлагыг дээд шатны байгууллагатай, нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас хуваарилсан санхүүжилтийг хариуцсан албан тушаалтантай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчилд 3 албан шаардлага, авлагын үлдэгдлийг бууруулах 1 зөвлөмж өгсөн. Аудитын шийдвэрийн хэрэгжилт 78.4 хувьтай байна.

Хүснэгт. 13 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	3,550.0	3	2,016.3	56.8
Зөвлөмж	1	123.0	1	123.0	100.0
Дүн	4	3,673.0	4	2,139.3	78.4

Өмнөх оны аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахаар хүргүүлсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй ч зөрчлийн дүн өмнөх оноос 33.3 хувиар буурсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- ТТЗ-ийн харьяа байгууллагуудын төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх хувь хүмүүсээс авах 110.1 сая төгрөгийн 73.3 сая төгрөгийн албан шаардлага шийдвэрлэх шатанд байгаа асуудалд, 2025 онд үүссэн орон тооны цомхотголоор ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох тэтгэмжийн өр төлбөрт аудитын горим сорил хэрэгжүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ХХҮЕГ-ын ТТЗ болон харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 6,497.5 сая төгрөгийн 53 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 5,467.1 сая төгрөгийн зөрчил² илэрч, 57.5 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 4,830.3 сая төгрөгийн зөрчилд 27 албан шаардлага хүргүүлж, 579.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 44 зөвлөмжийг өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,467.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,585.6 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төсвийн төвлөрүүлсэн захирагчийн харьяа байгууллагууд:

ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 27 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүврийн аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 24 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 3 (*БЗД-ийн ХХҮГ, Нийслэлийн ХХҮГ, Ахмад настны үндэсний төв*) байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 6,488.3 сая төгрөгийн 50 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 5,256.5 сая төгрөгийн зөрчил илэрч, 57.5 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 4,737.4 сая төгрөгийн зөрчилд 25 албан шаардлага хүргүүлж, 461.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 43 зөвлөмжийг өгсөн.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 219.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 9.2 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 92.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 117.7 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

5.2.1 Албан шаардлага:

5.2.1.1. ХХҮЕГ-ын харьяа байгууллагууд нь зардлын эдийн засгийн ангилал зөрчиж бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс худалдан авах зардлаас 1.2 сая төгрөгийн, урсгал засварын зардлаас 4.1 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 79.8 сая төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 7.8 сая төгрөгийн, нийт 92.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;", Сангийн сайдын 2023 оны "Ангилал шинэчлэн батлах тухай" 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", тавдугаар хавсралтын 2 дахь хэсэг "Урсгал зардлын ангиллын тайлбар"-ыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангилал зөрчдөг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.1.2. Харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,744.8 сая төгрөгийн 128 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 6,488.3 сая төгрөгийн алдааг залруулсан ба залруулаагүй 5,256.5 сая төгрөгийн 78 зөрчил илэрсэн нь Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газраас харьяа байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д “төсвийн төвлөрүүлэн захирагч гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;” 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын үр дүнтэй хэрэгжүүлэн, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, зөрчлийг 30-оос доошгүй хувиар бууруулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт 1. Тайлант онд харьяа зарим байгууллагууд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулаагүй нэмэлт санхүүжилтийн дансанд 117.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ;”, 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх; гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад жил бүр тогтмол үүсдэг, давтагдах шинжтэй орлогыг бүрэн тооцож, төсвийн төсөлд төлөвлөн батлуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
А	1	3=5+7	4=6+8	5	6	7	8	9	10	11	12	13=11	14=12
1	ХХҮЕГ-ТТЗ	3	9,222.6			3	9,222.6	3	9,222.6	-	-	-	-
	ДҮН	3	9,222.6	-	-	3	9,222.6	3	9,222.6	-	-	-	-
1	Баянзүрх дүүргийн ХХҮГ	4	955,117.9	-	-	4	955,117.9	4	955,117.9				
2	Баянгол дүүргийн ХХҮГ	1	1,800.0	-	-	1	1,800.0	1	1,800.0	-	-	-	-
3	Налайх дүүргийн ХХҮГ	1	245.0	-	-	1	245.0	1	245.0	-	-	-	-
4	Сонгинохайрхан дүүргийн ХХҮГ	2	18,315.2	-	-	2	18,315.2	2	18,315.2	-	-	-	-
5	Өмнөговь аймгийн ХХҮГ	5	33,086.4	5	33,086.4	-	-	5	33,086.4	-	-	-	-
6	Өвөрхангай	1	117.8			1	117.8	1	117.8				
7	Булган аймгийн ХХҮГ	5	12,000.0	-	-	5	12,000.0	5	12,000.0	-	-	-	-
8	Завхан аймгийн ХХҮГ	2	99,593.5	-	-	2	99,593.5	2	99,593.5	-	-	-	-
9	Орхон аймаг ХХҮГ	5	220,060.4	1	199,706.8	4	20,353.6	5	220,060.4	-	-	-	-
10	Хөвсгөл аймгийн ХХҮГ	1	54,568.4	1	54,568.4			1	54,568.4				
11	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	5	7,724.5	1	372.2	4	7,352.3	5	7,724.5	-	-	-	-
12	Хан-Уул дүүргийн ХХҮГ	2	10,187.1	-	-	2	10,187.1	2	10,187.1	-	-	-	-
13	Багахангай дүүргийн ХХҮГ	3	30,518.1	-	-	3	30,518.1	3	30,518.1	-	-	-	-
14	Төв аймгийн ХХҮГ	1	566.6			1	566.6	1	566.6				
15	Нийслэлийн ХХҮГ	2	12,032.6	-	-	2	12,032.6	2	12,032.6	-	-	-	-
16	ХХҮЕГ	2	3,807,363.2	-	-	2	3,807,363.2	2	3,807,363.2	-	-	-	-
17	Дорноговь	2	68,580.3	-	-	2	68,580.3	2	68,580.3	-	-	-	-
18	Ахмад настны үндэсний төв	6	1,156,435.3	1	44.1	5	1,156,391.2	6	1,156,435.3	-	-	-	-
	Харьяа байгууллагуудын дүн	50	6,488,312.3	9	287,777.9	41	6,200,534.4	50	6,488,312.3	-	-	-	-
	Нийт алдааны дүн	53	6,497,534.9	9	287,777.9	44	6,209,757.0	53	6,497,534.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэрс	Аудитын код	Аудитын дүгнэлт				Нийт зөрчил		Үүнээс											
			Үүнээс						Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Түүвэрт	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо
1	ХХҮЕГ-ТТЗ	САГ-2026/15/НА-СТА-ТТЗ	1		1		3	210,500.5	-	-	2	92,897.7	1	117,602.8						
	ДҮН		1		1		3	210,500.5	-	-	2	92,897.7	1	117,602.8	-	-	-	-	-	-
1	ХХҮЕГ ТШЗ	САГ-2026/264/НА-СТА-ТШЗ	1			1	5	4,357,203.6			4	4,347,203.6	1	10,000.0					-	-
2	Архангай аймгийн ХХҮГ	АРА-2026/036/НА-СТА-ТШЗ	1	1			-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	БНСУ дахь ХНХҮТ	САГ-2026/36/НА-СТА-ТШЗ	1			1	3	138,440.5					3	138,440.5						
4	БГД-ийн ХХҮГ	НТАГ-2026/313/НА-СТА-ТШЗ	1	1			1	1,701.0					1	1,701.0						
5	БЗД-ийн ХХҮГ	НТАГ-2026/315/НА-СТА-ТШЗ	1		1		4	189,415.9			1	148,070.5	3	41,345.4						
6	БНД-ийн ХХҮГ	НТАГ-2026/719/НА-СТА-ТШЗ	1	1			1	-					1	-						
7	Булган аймгийн ХХҮГ	БУА-2026/31/НА-СТА-ТШЗ	1	1			3	13,800.0	2	11,700.0			1	2,100.0						
8	Баянхонгор аймгийн ХХҮГ	БНА-2026/001/НА-СТА-ТШЗ	1	1			-	-												
9	БХД-ийн ХХҮГ	НТАГ-2026/721/НА-СТА-ТШЗ	1	1			1	609.5					1	609.5						
10	Баян-Өлгий аймгийн ХХҮГ	БӨА-2026/165/НА-СТА-ТШЗ	1			1	-	-												
11	Говь-Алтай аймгийн ХХҮГ	ГАА-2026/001/НА-СТА-ТШЗ	1			1	2	4,124.7					2	4,124.7						
12	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	ГСА-2026/008/НА-СТА-ТШЗ	1	1			3	1,396.8			2	1,396.8	1	-						
13	Дархан-Уул аймгийн ХХҮГ	ДАА-2026/28/НА-СТА-ТШЗ	1	1			-	-						-						
14	Дорнод аймгийн ХХҮГ	ДОА-2026/013/НА-СТА-ТШЗ	1	1			5	48,368.5	2	379.4	1		2	47,989.1						
15	Дорноговь аймгийн ХХҮГ	ДГА-2026/66/НА-СТА-ТШЗ	1	1			5	33,425.6	1	487.8	3	30,119.9	1	2,817.9						

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

16	Дундговь аймгийн ХХҮГ	ДУА-2026/94/НА-СТА-ТШЗ	1	1			-	-	-			-	-	-	-	-	-	
17	Завхан аймгийн ХХҮГ	ЗАА-2026/213/НА-СТА-ТШЗ	1	1			2	8,400.0	-		2	8,400.0						
18	Налайх дүүргийн ХХҮГ	НТАГ-2026/458/НА-СТА-ТШЗ	1	1			1	4,378.9				1	4,378.9					
19	Нийслэлийн ХХҮГ	НТАГ-2026/460/НА-СТА-ТШЗ	1		1		5	88,099.5				5	88,099.5					
20	Орхон аймгийн ХХҮГ	ОРА-2026/013/НА-СТА-ТШЗ	1	1			7	10,475.4	1	400.0	1	2,171.7	5	7,903.7				
21	СБД-ийн ХХҮГ	НТАГ-2026/615/НА-СТА-ТШЗ	1	1			1	-				1						
22	СХД-ийн ХХҮГ	НТАГ-2026/462/НА-СТА-ТШЗ	1	1			1	8,557.7			1	8,557.7						
23	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	СЭА-2026/144/НА-СТА-ТШЗ	1	1			3	19,852.5	1	3,019.5	1	370.7	1	16,462.3	-	-	-	-
24	Сүхбаатар аймгийн ХХҮГ	СБА-2026/043/НА-СТА-ТШЗ	1		1		1	-				1	0.0					
25	Төв аймгийн ХХҮГ	ТӨА-2026/086/НА-СТА-ТШЗ	1	1			2	11,972.1			1	11,140.2	1	831.9				
26	Увс аймгийн ХХҮГ	УВА-2026/085/НА-СТА-ТШЗ	1	1			-	-	-	-		-	-	-	-	-	-	
27	Ховд аймгийн ХХҮГ	ХОА-2026/037/НА-СТА-ТШЗ	1		1		1	21,692.8				1	21,692.8					
28	Хан-Уул дүүргийн ХХҮГ	НТАГ-2026/616/НА-СТА-ТШЗ	1	1			4	17,115.5	-	-	-	-	4	17,115.5				
29	Хэнтий аймгийн ХХҮГ	ХЭА-2026/027/НА-СТА-ТШЗ	1		1		-	-										
30	Хөвсгөл аймгийн ХХҮГ	ХӨА-2026/109/НА-СТА-ТШЗ	1	1			1	1,829.4	1	1,829.4	-	-		-	-	-	-	
31	Чингэлтэй дүүргийн ХХҮГ	НТАГ-2026/618/НА-СТА-ТШЗ	1	1			2	165.0				2	165.0					
32	Өвөрхангай аймгийн ХХҮГ	ӨВА-2026/17/НА-СТА-ТШЗ	1	1			1	4,050.0			1	4,050.0	-	-				
33	Өмнөговь аймгийн ХХҮГ	ӨМА-2026/107/НА-СТА-ТШЗ	1	1			6	21,580.6			3	5,879.6	3	15,701.0				
34	Ахмад настны үндэсний төв	СТА-2026/17/НА-СТА-ТШЗ	1		1		7	249,888.1	2	39,673.8	4	170,034.3	1	40,180.0				
	ДҮН		34	24	3	7	78	5,256,543.6	10	57,489.9	25	4,737,395.0	43	461,658.7	-	-	-	-
	НИЙТ ДҮН		35	24	4	7	81	5,467,044.1	10	57,489.9	27	4,830,292.7	44	579,261.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс												
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХХҮЕГ-ТТЗ	3				1	-	2	-							
	ДҮН	3	-	-	-	1	-	2	-	-	-	-	-			
1	ХХҮЕГ ТШЗ	4	105,705.0			1	37,490.0	2	-	1	2	68,215.0				
2	БНСУ дахь ХНХҮТ	3	89,671.6			2	89,671.6	1	-							
3	Баянхонгор аймгийн ХХҮГ	4	198,563.8	1	200.0	2	97,046.0	1	101,317.8							
4	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	2	750.0			1	750.0	1	-							
5	Дархан-Уул аймгийн ХХҮГ	1	98,199.5					1	98,199.5							
6	Дорноговь аймгийн ХХҮГ	1	-					1								
7	Дундговь аймгийн ХХҮГ	1	936.6			1	936.6									
8	Нийслэлийн ХХҮГ	2	124,810.5					2	124,810.5							
9	Увс аймгийн ХХҮГ	1	148,604.9			1	148,604.9									
10	Хөвсгөл аймгийн ХХҮГ	1	58,178.0					1	58,178.0							
11	Өвөрхангай аймгийн ХХҮГ	1	210,642.2					1	210,642.2							
12	Ахмад настны ҮТ	1	-					1	-							
	ДҮН	22	1,036,062.1	1	200.0	8	374,499.1	12	593,148.0	1	2	68,215.0				
	НИЙТ ДҮН	25	1,036,062.1	1	200.0	9	374,499.1	14	593,148.0	1	2	68,215.0				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1114/А0175347

Улаанбаатар хот

САГ-2026/15/НА-СТА-ТТЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагууд нь зардлын эдийн засгийн ангилал зөрчин, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс худалдан авах зардлаас 1,246,900.00 (Нэг сая хоёр зуун дөчин зургаан мянга есөн зуун) төгрөгийн, урсгал засварын зардлаас 4,101,000.00 (Дөрвөн сая нэг зуун нэг мянган) төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 79,766,000.00 (Далан есөн сая долоон зуун жаран зургаан мянган) төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 7,778,800.00 (Долоон сая долоон зуун далан найман мянга найман зуун) төгрөгийн, нийт 92,892,700.00 (Ерэн хоёр сая найман зуун ерэн хоёр мянга долоон зуун) төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Сангийн сайдын 2023 оны "Ангилал шинэчлэн батлах тухай" 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", тавдугаар хавсралтын 2 дахь хэсэг "Урсгал зардлын ангиллын тайлбар"-ыг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин хөрөнгө бэлтгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Бауыржан/, Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газрын дарга /М.Мянганбуу/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1115/АД175347

Улаанбаатар хот

САГ-2026/15/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,744,855,822.00 (Арван нэгэн тэрбум долоон зуун дөчин дөрвөн сая найман зуун тавин таван мянга найман зуун хорин хоёр) төгрөгийн 128 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 6,488,312,258.00 (Зургаан тэрбум дөрвөн зуун наян найман сая гурван зуун арван хоёр мянга хоёр зуун тавин найман) төгрөгийн алдааг залруулсан ба залруулаагүй 5,256,543,564.00 (Таван тэрбум хоёр зуун тавин зургаан сая таван зуун дөчин гурван мянга таван зуун жаран дөрвөн) төгрөгийн 78 зөрчил илэрсэн нь Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газраас харьяа байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д “төсвийн төвлөрүүлэн захирагч гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;” 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг 30-иос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Бауыржан/, Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газрын дарга /М.Мянганбуу/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1116/А0175347

Улаанбаатар хот

САГ-2026/15/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа 7 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 482,364,300.00 (Дөрвөн зуун наян хоёр сая гурван зуун жаран дөрвөн мянга гурван зуун) төгрөгийн зөрчил илэрсэн нь чиг үүргийг хэрэгжүүлж буй албан тушаалтан болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;", 8 дугаар зүйлийн 8.4-т "Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.", Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцруулсан, давтан гаргасан зөрчилд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264730

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-23.Docx

1526181483

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Бауыржан/, Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газрын дарга /М.Мянганбуу/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ